



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/44

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аварга малчин, хошой аварга малчин, аварга саальчин, аварга тариаланч, аварга фермер шалгаруулах журмын болзлыг хангаж Гахай жилийн Цагаан сарын босгон дээр 2018 оны аймгийн аварга малчин, хошой аварга малчин, аварга саальчин, аварга тариаланч, аварга фермер нарын шагналын зардлыг хавсралтаар батлаж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 37 741 000 төгрөг /Гучин долоон сая долоон зуун дөчин нэгэн мянга/-ийг аймгийн Засаг даргын хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ


Zax A/44 Ch
02 00196

Аймгийн Засаг даргын 2019 оны
1 дүгээр сарын 23 ны өдрийн
А/44 дүгээр захирамжийн хавсралт

ГАХАЙ ЖИЛИЙН ЦАГААН САРЫН БАЯРЫГ ТОХИОЛДУУЛАН 2018 ОНЫ АЙМГИЙН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН, АВАРГА МАЛЧИН, АВАРГА СААЛЬЧИН, АВАРГА ТАРИАЛАНЧ, АВАРГА ФЕРМЕР НАРЫН ШАГНАЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Шагнах үзүүлэлт	Шалгаруулсан хүний тоо	Тэмдэг			Үнэмлэх			Тууз			Бэлэг дурсгал			Дагалдах мөнгөн шагнал /мян.төг/	Нийт дүн /мян.төг/
			Тоо	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Дүн /мян.төг/	Тоо	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Дүн /мян.төг/	Тоо	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Дүн /мян.төг/	Тоо	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Дүн /мян.төг/		
1	Аймгийн хошой аварга малчин	6	12	16.0	192.0	12	2.5	30.0	6	14.0	84.0	6	120.0	720.0	3,000.0	4,026.0
2	Аймгийн аварга малчин	60	120	15.0	1800.0	120	2.5	300.0	60	14.0	840.0	60	120.0	7200.0	18,000.0	28,140.0
3	Аймгийн аварга тариаланч	8	16	16.0	256.0	16	2.5	40.0	8	14.0	112.0	8	120.0	960.0	2,400.0	3,768.0
4	Аймгийн аварга фермер	1	1	16.0	16.0	1	2.5	2.5	1	14.0	14.0	1	120.0	120.0	300.0	452.5
5	Аварга саальчин	3	3	15.0	45.0	3	2.5	7.5	3	14.0	42.0	3	120.0	360.0	900.0	1,354.5
	НИЙТ ДҮН	78	152		2309.0	152		380.0	78		1092.0	78		9360.0	24,600.0	37,741.0

Ловд аймгийн засаг даргын
2019 оны 01 дүгээр сарын 23 ны өдрийн
А/43 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН "ЕСӨН АЛДАРТАН"-ЫН ШАГНАЛЫН ТӨСӨВ

Д.д	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /мян.төг/
1. Аймгийн есөн алдартан				
1	Энгэрийн тэмдэг	9	10000	90.0
2	Үнэмлэх	9	2500	22.5
3	Тууз	9	14000	126.0
4	Бэлэг дурсгалын зүйл	9	150000	1350.0
	Дүн			1588.5

.-оОо-